

MODEL UN STARTER KIT:

ЗАГВАР НҮБ-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД БОЛОН ОРОЛЦОГЧДОД
ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



2025

АГУУЛГА

I-Р ХЭСЭГ: ТАНИЛЦУУЛГА

- 1.1 НҮБ-ЫН ДОЛОО ХОНОГТ ТАВТАЙ МОРИЛ
- 1.2 ЗАГВАР НҮБ ГЭЖ ЮУ ВЭ?

II-Р ХЭСЭГ: ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАГЧДАД

- 2.1 ЗОРИЛГО БОЛОН СУРГАЛТЫН ҮР ДҮН
- 2.2 ТОХИРОХ ФОРМАТЫГ СОНГОХ НЬ
- 2.3 ХОРООД БОЛОН СЭДВИЙГ СОНГОХ
- 2.4 ЛОГИСТИК БОЛОН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

III-Р ХЭСЭГ:: ХУРАЛДААНД ОРОЛЦОГЧ ТӨЛӨӨЛӨГЧДӨД

- 3.1 ХУРАЛДААНДАА БЭЛДЭХ НЬ
- 3.2 ТӨЛӨӨЛӨГЧДИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ ХУУДАС
- 3.3 ЖИШЭЭ БАЙР СУУРИЙН БИЧИГ(PPOSITION PAPER)

MODEL UN STARTER KIT:

PART I: INTRODUCTION



1.1 НҮБ-ЫН ДОЛОО ХОНОГТ ТАВТАЙ МОРИЛ

1945 онд дэлхийн II дайн холбоотнуудын ялалтаар өндөрлөж, хүн төрөлхтөн дахин дайн дэгдэхээс сэргийлж, энх тайвныг сахин хамгаалах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагыг байгуулсан билээ. Тэр цагаас хойш даруй 80 жил өнгөрч, 2025 онд дэлхий нийтээрээ Нэгдсэн Үндэстний Байгууллага байгуулагдсаны 80 жилийн ойг тэмдэглэх гэж байна. 80 жилийн ойн хүрээнд 2025 оны 10-р сарын 20–24-ын хооронд зохиогдох гэж буй “НҮБ-ын долоо хоног”-ийг тохиолдуулан Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн багш, сурагчдыг өөрийн сургуульдаа Загвар НҮБ-ыг зохион байгуулж, нэгэн өдрийг мэтгэлцэж, сэтгэлцэж, бие биеэсээ суралцаж өнгөрүүлэхийг Монгол улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагаас уриалж байна.

1.2 ЗАГВАР НҮБ ГЭЖ ЮУ ВЭ?

Загвар НҮБ нь сурагчид тодорхой улсын төлөөлөгч, дипломатчийн дүрд хувиран дэлхий нийтэд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэн мэтгэлцэж, бусад улсын төлөөлөгчидтэй санал солилцож, шийдэл бүхий тогтоолын төсөл боловсруулдаг сургалтын арга барил юм. Өөрөөр хэлбэл, энэ нь НҮБ-ын хурал чуулган дээр болдог бодит үйл явц, процессыг сургуулийн танхимд “амилуулдаг” симуляци юм.

Загвар НҮБ хуралдааныг зохион байгуулснаар сурагчид:

- Аливаа улсын удирдагч, төлөөлөгчийн дүрд тоглож, тухайн улсын үндэсний ашиг сонирхол ба олон улсын хамтын нийгэмлэгийн талаарх анхан шатны ойлголт олж авах
- Мэтгэлцээн замаар хэлэлцээр хийж зөвшилцөлд хүрэх ур чадвараа хөгжүүлэх
- Өөрийн байр суурийг олны өмнө мэдэгдэл хийж, үг хэлэх байдлаар танилцуулснаар өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх
- Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжил, хүний эрх, олон улсын аюулгүй байдал зэрэг бодит асуудлыг шийдэхэд оролцох зэрэг ач холбогдолтой.

Загвар НҮБ-д оролцоноор сурагчид НҮБ болон НҮБ-ын төрөлжсөн агентлагуудын үйл ажиллагаа талаар ерөнхий ойлголт авахаас гадна олон талт хамтын ажиллагаа, мэтгэлцээн, шийдвэр гаргах замаар НҮБ-ын зарчим, үнэт зүйлсийг ухамсарлах боломжийг олгодог. Ингэхдээ сурагчид өөрсдөө оролцож **хийж бүтээх замаар суралцах** явдал. Ингэхдээ сурагчид өөрсдөө оролцох замаар практик дадлага олж авч, олон улсын харилцаанд шийдвэр гаргалт хэрхэн явагддагийг өөрсдийн биеэр мэдэрдэг онцлогтой.

Жишээлбэл:

- Уур амьсгалын өөрчлөлтийн хороонд **Япон улсыг төлөөлж буй оюутан** өөрийн хувийн байр суурьтай зөрчилдөж байсан ч бодит амьдрал дээрх Япон Улсын бодлогыг хамгаалах ёстой.
- Аюулгүйн Зөвлөлийн хуралд **Бразилыг төлөөлсөн оюутан** бүс нутгийн ашиг сонирхлыг дэлхийн хамтын хариуцлагатай тэнцвэржүүлэх шаардлагатай болно.

Иймэрхүү амьдрал дээрх бодит жишээнд тулгуурласан динамик арга барилыг ашигладаг нь Загвар НҮБ-ыг оюуны хувьд сорилттой бөгөөд сонирхолтой болгодог.

Загвар НҮБ хуралдаан хэрхэн өрнөдөг вэ?

Загвар НҮБ хуралдаанд дараах үе шат багтана:

1. **Нээлтийн үг** – Улс орнууд аливаа асуудлаар өөрийн байр сууриа товч илэрхийлнэ.
2. **Албан мэтгэлцээн** – Хурлын тодорхой дэг журам, дүрмийн дагуу явагдана.
3. **Албан бус мэтгэлцээн (бүлэглэл)** – Төлөөлөгчид чөлөөтэй ярилцаж, байр сууриа ойлголцож, дундын ашиг сонирхолд хүрэхийг оролдоно.
4. **Тогтоолын төсөл боловсруулах** – Дийлэнх олонхын саналаар сонгогдсон асуудлын шийдлийг тусгасан баримт бичгийг хамтдаа боловсруулна.
5. **Санал хураалт** – Тогтоолын төслийг батлах эсэхийг шийдвэрлэнэ.

A group of five people in business attire are gathered around a laptop. A man in a dark suit and tie is pointing at the screen, while others look on attentively. The scene is overlaid with a blue tint and a white geometric pattern.

MODEL UN STARTER KIT:

PART II: FOR ORGANIZERS

A group of people are seated at a long table with several laptops open. They appear to be in a meeting or workshop, looking at the screens and talking. The image is overlaid with a blue tint and a white geometric pattern.

2.1 ЗОРИЛГО БОЛОН СУРГАЛТЫН ҮР ДҮН

Загвар НҮБ-ыг амжилттай хэрэгжүүлэх нь сургуулийн анги танхимыг дипломат яриа хэлэлцээний бодит орчин болгож хувиргадаг. НҮБ-ын долоон хоногийн хүрээнд Загвар НҮБ-ыг зохион байгуулах сурагчдад дараах ач холбогдолтой:

- Олон улсын хамтын ажиллагаа хэрхэн өрнөдөг талаар тодорхой ойлголттой болно.
- Олны өмнө илтгэл тавьж өөрөө илүү итгэлтэй болж, өөр үнэт зүйл, ялгаатай ашиг сонирхолтой нэгнийг ойлгож, бусдыг сонсож сурна.
- Судалгаа, нотолгоотойгоор өөрийн байр сууриа илэрхийлэх дадалтай болно.

Зохион байгуулагчдын хувьд: Загвар НҮБ-ыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэх боломжтой бөгөөд мөн хуралдааны цар хүрээг үе шаттайгаар (анги → ангиуд → сургууль) тэлж болдгийг харуулах нь зорилготой.

2.2 ТОХИРОХ ФОРМАТЫГ СОНГОХ НЬ

Загвар НҮБ-ыг хэрэгжүүлэхдээ сургуулийнхаа нөхцөл, нөөц боломж, сурагчдын идэвхтэй оролцоонд тохируулан формат сонгох боломжтой.

Анги доторх:

- Нэг ангид нэг хороо (жишээ нь: Ерөнхий Ассамблей)
- Багш эсвэл өмнө нь Загвар НҮБ хуралдаанд оролцож байсан туршлагатай сурагч хуралдааныг даргалж зохион байгуулна
- Хуралдааныг 45-90 минутын хичээлийн цаг дээр зохион байгуулахад тохиромжтой
- Төлөөлөгчдийн плакарднаас өөр хэвлэмэл материал шаардлагагүй

Анги хоорондын:

- Нэг сэдвийг олон анги хамтарч хэлэлцэх эсвэл хоёр хороо зэрэг ажиллах (жишээ нь, Ерөнхий Ассамблей + ДЭМБ)
- Сурагчид өөрсдөө даргалах боломжтой
- Нээлт, хаалтын ажиллагаанд зориулсан том танхим шаардлагатай

Сургуулийн хэмжээний:

- Олон хороо зэрэг хуралдана
- Сурагчид дундаас нарийн бичгийн дарга нарын баг үүсгэх
- Нээлт, хаалтын ёслол, шагнал гардуулах арга хэмжээтэй

- Амжилттай зохион байгуулахад сурагчдын идэвх, манлайлал болон сургуулийн удирдлагуудын дэмжлэг чухал

Зөвлөмж: Хэрэв танай сургууль Загвар НҮБ-ыг анх удаа хэрэгжүүлж байгаа бол энэ жил анги доторх эсвэл анги хоорондын форматыг сонгож, ирэх жилээс сургуулийн түвшинд зохион байгуулах байдлаар үйл ажиллагаагаа өргөжүүлээрэй.

2.3 ХОРООД БОЛОН СЭДВИЙГ СОНГОХ

Анх удаа Загвар НҮБ-д оролцож буй сурагчдад зориулж нэг хороо, тодорхой бүтэцтэй нэг сэдвийг сонгох нь хамгийн оновчтой. Сэдэв аливаа нэг асуудал дээр төвлөрсөн нарийвчилсан байх тусам мэтгэлцээн илүү үр дүнтэй өрнөнө.

Анхлан зохион байгуулахад тохиромжтой хороод:

- **Ерөнхий Ассамблей (GA):** Хамгийн өргөн оролцоотой, Улс орон бүрд төлөөлөгч оноох боломжтой.
- **UNESCO / НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP):** Тодорхой чиг үүрэгтэй байгууллагууд тул анх удаагаа зохион байгуулж буй тохиолдолд сурагчдад ойлгоход хялбар. Өдөр тутмын амьдралтай нь холбоотой асуудал хөнддөг онцлогтой.
- **ДЭМБ/НҮБ-ын Хүүхдийн Сан:** Залуучууд, хүүхдэд шууд хамаарах асуудал хэлэлцдэг тул сургуулийн насныханд илүү ойр.

Монгол Улсад хамаарах жишиг сэдвүүд (Нэгийг сонгох):

- Ерөнхий Ассамблей: *“Хотын төвийн агаарын бохирдлын асуудлыг шийдвэрлэх нь”*
- НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (UNEP): *“Хуурай бүс нутгийн цөлжилт, газрын доройтолтой тэмцэх нь”*
- ДЭМБ: *“Цар тахлын дараах үеийн өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих үйлчилгээг сайжруулах нь”*
- НҮБ-ын Хүүхдийн Сан: *“Хүүхдийг цахим дарамт, дээрэлхэл ташаа мэдээллээс хамгаалах нь”*
- ЮНЕСКО: *“Боловсролыг хөдөө орон нутагт хүртээмжтэй, чанартай байдлаар хангах нь”*

Зөвлөмж: Сэдвийг өргөн хүрээтэй томоохон нэр томъёогоор бус, тодорхой асуулт эсвэл сорилт байдлаар томъёолох нь зүйтэй.

2.4 ЛОГИСТИК БОЛОН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Анги танхим, суудлын зохион байгуулалт

Зөв уур амьсгалыг бүрдүүлэхийн тулд төлөөлөгчид бие биеэ харж чадахуйц суудлын зохион байгуулалт хэрэгтэй. Ширээг “П” эсвэл дугуй хэлбэрээр байрлуулж засвал тохиромжтой. Суудал бүр дээр сурагчийн төлөөлж буй улсын нэр бүхий плакардыг А4-ын цаасан дээр хэвлэн, нугалж байршуулаарай.

Зохион байгуулагч урьдчилан дараах зүйлсийг бэлдэх шаардлагатай:

- Төлөөлөгчдөд оноосон улс орнуудын жагсаалт
- Суудлын зохион байгуулалтад хэрэглэх улсын нэр бүхий плакард
- Хурлын даргалагчийн ашиглах модон алх(Заавал биш)

Эдгээр зүйлс нь арга хэмжээнд албан ёсны уур амьсгал оруулж, сурагчдыг илүү нухацтайгаар төлөөлөгчийн дүрдээ тоглох урам зоригийг өгдөг.

Цагийн менежмент, хурлын явц

Хуралдааныг цагаа баримтлан, төлөвлөгөөний дагуу явуулах нь зохион байгуулагчид тулгарах хамгийн гол сорилт. Хэрэв товч хурал (45–90 минут) төлөвлөж байгаа бол дараах байдлаар зохион байгуулж болно:

1. Хуралдааны нээлт, төлөөлөгчдөд суудлаа эзлэх
2. Ерөнхий мэтгэлцээн (илтгэгчдийн жагсаалтаар)
3. Бүлгийн хуралдаан (албан ёсны болон албан бус хэлэлцүүлэг)
4. Тогтоолын төсөл боловсруулах, танилцуулах
5. Санал хураалт ба хаалтын үг

MODEL UN STARTER KIT:

PART III: FOR DELEGATES



3.1 ХУРАЛДААНДАА БЭЛДЭХ НЬ

Хуралдааны өдөр ашиглагдах үндсэн нэр томьёо

Үндсэн нэр томьёо

- **Motion:** Даргад хандан санал хүсэлт тавих (жишээ нь, бүлгийн хурал зарлах).
- **Point of Order:** Процедурын алдаа засан залруулах хүсэлт.
- **Point of Information:** Илтгэл дууссаны дараа асуух асуулт (заримдаа зөвшөөрөгдөнө).
- **Moderated Caucus:** Сэдвийн хүрээнд хугацаатай, богино илтгэлүүдээр мэтгэлцэх.
- **Unmoderated Caucus:** Бусад орны төлөөлөгчидтэй чөлөөтэй ярилцаж, өөрийн блокоо үүсгэн санал нэгдэж бичвэр боловсруулах үе.
- **Working Paper:** Тогтоолын төсөл болох боломжтой санаануудын цуглуулга ноорог.
- **Draft Resolution:** Хороогоор батлуулахыг зорьсон албан ёсны тогтоолын төсөл бүхий баримт бичиг.
- **Sponsors:** Төслийг хамтдаа бичилцсэн гол санаачлагчид.
- **Signatories:** Төслийг хамтран бичилцээгүй ч хэлэлцэхийг зөвшөөрөн гарын үсгээ өгсөн төлөөлөгчид.

3.2 ТӨЛӨӨЛӨГЧДИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ ХУУДАС

Загвар НҮБ-д анх удаагаа оролцож байгаа төлөөлөгчдөд хуралдааны бүтэц, хуралдааны үеэр баримтлагдах дэг журам, хэрэглэгддэг үг хэллэг ойлгомжгүй, төвөгтэй санагдаж магадгүй юм. Хүн аливаа зүйлийг анх удаагаа хийж үзэхдээ сандарч, тэвдэх алдаа гаргах нь хэвийн үзэгдэл. Гэхдээ төлөөлөгч та энэхүү жагсаалтын дагуу бэлтгэлээ хангахдаа дараах жагсаалтын дагуу

1. Улс орон ба хорооныхоо талаар судлах

- Сонгож авсан улсын байр суурь, гадаад бодлого, сүүлийн үеийн мэдэгдлүүдийг уншиж тэмдэглэл хөтлөх
- Сэдэвтэй холбоотой эвсэл, хамтын ажиллагаа, түүхэн байр суурь, өмнөх тогтоол, олон улсын гэрээнүүдийг шалгах
- Томилогдсон хорооныхоо (Ерөнхий Ассамблей, Аюулгүйн Зөвлөл, Төрөлжсөн Агентлаг) үүрэг, журмыг ойлгох

2. Байр суурийн бичиг (Position Paper) боловсруулах

- Сэдвийн үндэслэл, асуудлын ач холбогдлыг тайлбарлах.
- Тухайн улсын онцлог байр суурь, үндэслэлээ тодорхой болгох.
- Санал болгож буй шийдлийг тусгах.
- Үүнийг тухайн улсын албан ёсны бодлоготой нийцсэн хэлбэрээр бичих.

3. Илтгэлдээ бэлтгэх

- Ерөнхий мэтгэлцээний жагсаалтад зориулж 30 секундийн илтгэл бэлдэх.
- Хэллэг, өнгө аясыг нухацтай шалгах илтгэж буй байдлаар гэртээ давтах.
- Сандарч тэвдэлгүй, өөртөө итгэлтэй байдлаар илтгэхийг оролдох.

4. Үндсэн дүрэм, хуралдааны дэгийг ойлгох

- Мэтгэлцээний үеийн үндсэн үйл явцыг ойлгох: санал хураалт, бүлгийн хуралдаан, тогтоол боловсруулах гэх мэт дүрэм, явагдах процессыг ойлгох.
- Гол нэр томъёо, хурлын дэгтэй танилцах.

5. Дипломат харилцааны стратеги гаргах

- Боломжит холбоотон, өрсөлдөгчөө тодорхойлох.
- Зохицуулаагүй бүлгийн хуралдаан(Unmoderated Caucus)-ы үеэр хэлэлцээр хийх төлөвлөгөө бодож бэлдэх.
- Өөрийн байр суурийг хамгаалах ч харилцан ойлголцолд хүрэх боломж нээлттэй байх.

6. Хувийн бэлтгэлээ хангах

- Байр суурийн бичиг, тэмдэглэл, илтгэлээ авчрах.
- Тогтоол боловсруулахад хэрэг болох бичгийн хэрэгсэл, тэмдэглэлээ бэлэн байлгах.
- Аргументуудаа дэмжих гол баримт, статистиктай байх.

7. Хамтран ажиллах дадлага хийх

- Найз нөхөд, хамт олонтойгоо мэтгэлцээн, хэлэлцээрийг туршиж үзэх
- Бусдыг сонсож, хүндэтгэлтэй хариулах дадлага хийх
- Дипломат уур амьсгалыг хадгалсан, товч бөгөөд тогтсон тодорхой хэллэгүүдийг хэрэглэх.

8. Идэвх оролцоо

- Мэргэжлийн уур амьсгалд тохируулж албан ёсны хувцаслах.

- Уян хатан байх: мэтгэлцээн төлөвлөснөөс өөрөөр эргэх магадлалтай тул бэлтгэлтэй байх.

Загвар НҮБ нь тэмцээн уралдаан биш анх удаагаа оролцож байгаа хэн бүхний алдах эрхтэй талбар тул хуралдааны өдөр өөртөө итгэлтэйгээр оролцоорой.

3.3 ЖИШЭЭ БАЙР СУУРИЙН БИЧИГ(PPOSITION PAPER)

Хороо: Ерөнхий Ассамблей – Нэгдүгээр хороо (Зэвсэг хураах ба олон улсын аюулгүй байдал)

Сэдэв: Кибер аюулгүй байдал ба олон улсын энх тайван

Улс: Бүгд Найрамдах Солонгос Улс

Байр суурийн бичиг

Кибер аюулгүй байдлын эрсдэл нь өнөө цагт олон улсын энх тайван, тогтвортой байдалд заналхийлж буй хамгийн том сорилтуудын нэг болоод байна. Улс орнуудын төрийн сүлжээ, санхүүгийн байгууллага, зайлшгүй шаардлагатай дэд бүтэц рүү чиглэсэн халдлагууд нь зөвхөн үндэсний аюулгүй байдалд бус иргэдийн өдөр тутмын амьдралд ч аюул авчирдаг.

НҮБ-аас хэд хэдэн алхам хийсэн бөгөөд үүнд “Дижитал эринд хүний эрхийг хамгаалах тухай тогтоол” (A/RES/68/167) багтдаг. Гэвч дэлхийн түвшинд илүү нягт хамтын ажиллагаа шаардлагатай хэвээр байна.

Бүгд Найрамдах Солонгос Улс кибер аюулгүй байдлыг улс бүрийн дангаараа бус, хамтын хүчээр даван туулах ёстой сорилт гэж үздэг. Технологийн өндөр хөгжилтэй орны хувьд Солонгос Улс аюулгүй дижитал дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулж, бүс нутгийн яриа хэлэлцээнд (жишээ нь, АСЕАН форум) идэвхтэй оролцож ирсэн.

Солонгос Улсын санал болгож буй шийдлүүд:

- Кибер халдлагын эсрэг хариу арга хэмжээг зохицуулах, шилдэг туршлагыг хуваалцах зорилгоор НҮБ-аар ахлуулсан олон улсын ажлын хэсэг байгуулах.
- Хөгжиж буй орнуудын кибер хамгаалалтын чадавхыг нэмэгдүүлэх сургалт, дэмжлэгийн хөтөлбөрүүдийг өргөжүүлэх.
- Засгийн газар болон технологийн компаниудын түншлэлийг бэхжүүлж, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Улс орнууд хамтын ажиллагаагаа өргөжүүлснээр кибер халдлагын эрсдэлийг бууруулж, дэлхий нийтээрээ энх тайван, аюулгүй байдлыг хамгаалах боломжтой.



ТАНЫ ЗАГВАР НҮБ-ЫН АЯЛАЛ ЭХЭЛЛЭЭ!

Та ийнхүү Загвар НҮБ-ын анхны аялалдаа гарахад бэлэн боллоо. Энэхүү гарын авлага нь төлөөлөгчийн дүрд орохоор бэлтгэж буй сурагч эсвэл анги, сургуулийнхаа Загвар НҮБ-ыг удирдан зохион байгуулах гэж буй багш ч мөн адил хэрэглэж болох зааварчилгаа бүхий газрын зураг юм.

Сурагчдын хувьд Загвар НҮБ нь зүгээр нэг симуляци биш бөгөөд харин манлайлал, хамтын ажиллагаа, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх алдах эрхтэй дадлагын талбар билээ. Та илтгэл тавих, хэлэлцээ хийх, шийдвэр гаргах бүрдээ дэлхий дахинд тулгамдаж буй асуудлыг илүү гүнзгий ойлгож, дипломат ур чадвараа хөгжүүлж, өөрийн үзэл бодлоо итгэлтэй илэрхийлэх боломжтой.

Багш, зохион байгуулагчдын хувьд Загвар НҮБ нь сурагчдадаа шинийг туршиж үзэх, харилцан бие биеэсээ суралцах, хөгжих орчныг бүрдүүлэх боломж юм. Мэтгэлцээн, буулт, гарсан шийдвэр бүр нь сурагчдын хувь хүний өсөлт хөгжилд бодит хувь нэмэр оруулна. Энэхүү туршлага нь тэдний дан ганц ур чадварыг хөгжүүлэх бус, багийн уур амьсгал, хамт олонч байдал, харьяалагдах мэдрэмжийг бий болгохоос гадна улс орны хүрээнд бус дэлхий дахины хэмжээнд томоор сэтгэх чадварыг төлөвшүүлдэг.

НҮБ 2025 онд даян дэлхийн хамтын ажиллагааны 80 жилийн ойг тэмдэглэж байна. Сурагчийн ширээний ард сууж буй та бүгд ирээдүйн дипломат харилцаа, манлайлал, эерэг өөрчлөлтийн эзэд юм. Тиймээс НҮБ-ын долоо хоногийн үеэр зохион байгуулах Загвар НҮБ хуралдаандаа бэлтгэлтэй, өөртөө итгэлтэй хамгийн гол нь сониуч зантайгаар оролцоорой. Таны анхны Загвар НҮБ хуралдаанаас олж авах мэдлэг, мэдрэмж, туршлага тань сурагчийн ширээний ардаас давсан шинэ аяллын эхлэл байх болтугай.

MODEL UN STARTER KIT:

ЗАГВАР НҮБ-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД БОЛОН ОРОЛЦОГЧДОД
ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



2025